



ДУНГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 07

Мандалговь

Хөрөнгө худалдах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2.1.7, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:


1. Говь-Угтаал сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 35,814,533.76 /Гучин таван сая найман зуун арван дөрвөн мянга таван зуун гучин гурван төгрөг далан зургаан мөнгө/-ний анхны өртөгтэй, 19,548,766.36 /Арван есөн сая таван зуун дөчин найман мянга долоон зуун жаран зургаан төгрөг гучин зургаан мөнгө/-ний хуримтлагдсан элэгдэлтэй цэцэрлэгийн хуучин барилгыг худалдах үнийн доод хязгаарыг 12,000,000.00 /Арван хоёр сая төгрөг/-өөр, Сум дундын эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 11,000,000.00 /Арван нэгэн сая төгрөг/-ний анхны өртөгтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн 39-04 ДУА улсын дугаартай УАЗ-315122 маркын автомашиныг худалдах үнийн доод хязгаарыг 1,500,000.00 /Нэг сая таван зуун мянган төгрөг/-өөр, Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 35,288,757.00 /Гучин таван сая хоёр зуун наян найман мянга долоон зуун тавин долоон төгрөг/-ний анхны өртөгтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн Ажирхай багийн хуучин конторын барилгыг худалдах үнийн доод хязгаарыг 5,000,000.00 /Таван сая төгрөг/-өөр тус тус тогтоон худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Говь-Угтаал сумын Хүүхдийн цэцэрлэг /А. Алтанчимэг/-т, Засаг даргын тамгын газар /Г.Эрдэнэцэцэг/-т тус тус даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



0100012